



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 8/121

Улаанбаатар хот

Г Монгол Улсын Харилцаа холбооны
сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөнд
нэмэлт оруулах тухай


Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дах заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:


1. Тус газрын даргын “Монгол Улсын Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай” 2018 оны А/104 тоот тушаалаар баталсан Монгол Улсын Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний 3.3 дах хэсэгт заасан Яаралтай тусlamжийн зориулалттай тусгай дугаарлалтад ашиглагдах дугаарын багцын “112” гэсний дараа “110, 1111” гэж нэмсүгэй.
2. Уг дугаарлалтын төлөвлөгөөний 3.3.1 дэх заалтыг “Яаралтай тусlamжийн зориулалттай тусгай дугаарлалт нь гоц халдварт, түргэн тусlamж, онцгой байдал, гамшгийн, гал түймрийн, цагдаагийн шуурхай болон нийгэмд үүсэх сөрөг үзэгдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх дуудлагын үйлчилгээнд хэрэглэгчид тухайн орон нутгийн цахилгаан холбооны сүлжээнээс үнэ төлбөргүй холбогдох хязгаарлагдмал нөөц бүхий 3 цифрээс бүрдсэн багц дугаарлалт байна.” гэж өөрчилсүгэй.
3. Дээрх өөрчлөлтийг мөрдлөг болгон хэрэгжилтийг зохион байгуулахыг Харилцаа холбооны зохицуулах хороо /Г.Чинзориг/-нд үүрэг болгосугай.



ДАРГА

Б.ЧИНБАТ





А. Уратогийн

Болотину, С.

Нийисон.

Хувь

2019 он ог сары 4